



# ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

---

## ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ҮР ДҮНД (ГҮЙЦЭТГЭЛ) СУУРИЛАН ТӨСӨВЛӨХӨД ӨГСӨН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

---

Тайлан бичсэн: **Д.Намхайдагва**

/Удирдлагын академийн Бодлого, улс төр  
судлалын тэнхимийн ахлах багш/

Улаанбаатар хот

2023 он

## АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт .....	3
Зургийн жагсаалт .....	4
Товчилсон үгийн жагсаалт .....	5
ажлын даалгавар .....	6
НЭГ. Үр дүнд суурилсан төсөвлөлт .....	8
1.1. Төсөвлөлтийн аргууд: Онцлог, ялгаа, уялдаа, эерэг, сөрөг үр дагавар.....	8
1.2. Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийн шинэчлэлийн тойм .....	11
1.3. Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлсэн төрийн байгууллагууд, тэдгээр гарсан ахиц, шийдвэрлэвэл зохих тулгамдаж буй асуудал .....	13
1.4. Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлэхэд анхаарах асуудал .....	14
хоёр. Шез-ийн тез-ийн хөтөлбөрийн үр дүн, үр дүнгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох нь	16
2.1. ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр дүн, үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлох нь....	16
2.2. Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг тодорхойлох нь .....	17
2.3. Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх арга хэмжээг тодорхойлох нь .....	18
2.4. Хөтөлбөрийн үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтийг Төсвийн шууд захирагч тус бүрээр тодорхойлох нь.....	18
ГУРАВ. Шез-ийн тез-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааны зардлын төсвийн тооцоолол	20
3.1. ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг Төсвийн эдийн засгийн ангилалтай уялдуулах нь .....	20
3.2. ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгжийн өртөг ба нийт төсвийг тооцох нь.....	21
Эх сурвалжийн жагсаалт .....	22
ХАВСРАЛТЫН жагсаалт .....	23

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2024 оны төсвийн төлөвлөлтийн хүрээнд Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэх туршилтыг хэрэгжүүлж буй ТЕЗ-ийн хөтөлбөрүүд .....	14
Хүснэгт 2. Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлэх давуу, сул тал болон боломж, эрдсэл .....	14



## Зургийн жагсаалт

Зураг 1. Төрийн бодлогын үйл явц.....	9
Зураг 2. Төрийн бодлогын үйл явц ба төсөвлөлт .....	10
Зураг 3. Уламжлалт төсөв ба Үр дүнд чиглэсэн төсвийн ялгаа .....	10



## Товчилсон үгийн жагсаалт

БШУ	Боловсрол, Шинжлэх ухаан
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОН	Орон нутаг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
УТ	Улсын төсөв
ҮДСТ	Үр дүнд суурилсан төсөвлөлт
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллага



## ажлын даалгавар

Ажлын даалгаврын нэр:	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийг үр дүнд (гүйцэтгэл) суурилан төсөвлөх талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын даалгавар</b>
Захиалагч байгууллага:	Шүүхийн ерөнхий зөвлөл
Хариуцах нэгж, хэлтэс	Захиргаа, удирдлагын газар
Байршил:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Тасганы овоо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр
Оршил:	Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 332 дугаар тогтоолоор “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого” батлагдсан. Тус баримт бичгийн I.3.3-т “Шүүн таслах ажиллагааны зардлыг бодитой тооцох, төлөвлөх, санхүүжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж шүүхийн эдийн засгийн баталгааг хангах” арга хэмжээ тусгагдсан.
Гүйцэтгэх ажил үүрэг:	<p><b>1.Дараах агуулга бүхий судалгааны тайлан боловсруулж хүлээлгэн өгөх:</b></p> <p>-үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн талаар Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам зэрэг холбогдох байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичгийн тойм,</p> <p>-үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн онцлог, ялгаа, уялдаа, эерэг, сөрөг үр дагавар,</p> <p>-үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлсэн төрийн байгууллагууд, тэдгээрт гарсан ахиц, шийдвэрлэвэл зохих тулгамдаж буй асуудал,</p> <p>-үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэхэд шүүхийн салбарт нэвтрүүлэхэд анхаарах асуудал.</p> <p><b>2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн үр дүн, арга хэмжээ, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт зэргийг тодорхойлоход системчлэл, агуулга, арга зүй, томьёоллын зэрэг асуудлаар зөвлөгөө өгөх</b></p> <p><b>3.шүүн таслах ажил, бодлого удирдлагын үйл ажиллагааг төлөвлөх, зардлыг тооцоолоход арга зүйн зөвлөгөө өгөх</b></p>
Даалгаврын хугацаа, үе шат:	Нийт хугацаа: Ажил үүргийг 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 8-ны өдрийн хооронд гүйцэтгэж үр дүнг хүлээлгэн өгнө. Дараах үе шатаар үр дүнг хүлээлгэн өгнө: 1.Гүйцэтгэх ажил үүргийн 1-д заасан судалгааны ажлыг 2023 оны 8 дугаар сарын 21-ний өдөр хүлээлгэн өгнө. 2.Гүйцэтгэх ажил үүргийн 2 болон 3-т заасан ажил үүргийг гэрээт ажлын хугацаанд хийж гүйцэтгэнэ.
Багийн бүтэц, бүрэлдэхүүн:	Хувь хүн
Тавигдах шаардлага, ажлын туршлага:	<p>1.төрийн удирдлага, бодлогын чиглэлээр магистр, түүнээс дээш зэрэгтэй байх;</p> <p>2.төрийн удирдлага, бодлогын чиглэлээр 15 доошгүй жил ажилласан байх</p> <p>3.үр дүн буюу гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршлагатай байх;</p> <p>4.судалгааны ном, тайлан, эмхэтгэл, зөвлөмж, илтгэл, өгүүллийн жагсаалтыг хавсаргах;</p> <p>5.хариуцсан ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, богино хугацаанд ачаалалтай ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай байх.</p> <p>6.үр дүн буюу гүйцэтгэлд суурилсан төсвийн төлөвлөлтийн чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байсан бол давуу тал болно.</p>

Ажлын зохион байгуулалт, үр дүнг тайлагнах	<ol style="list-style-type: none"><li>1.Гүйцэтгэгч нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргатай гэрээ байгуулж ажиллана.</li><li>2.Гүйцэтгэгч Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн (цаашид “Ажлын хэсэг” гэх) ахлагчтай ажил үүргийн аливаа асуудлаар тухай бүр харилцана.</li><li>3.Гүйцэтгэгч судалгааны ажлын эцсийн үр дүнг Ажлын хэсэгт тайлагнах бөгөөд судалгааны тайланг цаасан болон цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.</li><li>4.Гүйцэтгэгч нь шаардлагатай мэдээ, мэдээлэл, тоо, баримт, датаг Ажлын хэсгээс гаргуулан авч Ажлын хэсэгт холбогдох чиглэлээр тухай бүр харилцаж зөвлөгөө өгөх, уулзалт, ярилцлага хийх зэргээр зөвлөнө.</li></ol>
--	--

--oOo--



## НЭГ. үр дүнд суурилсан төсөвлөлт

### 1.1. Төсөвлөлтийн аргууд: Онцлог, ялгаа, уялдаа, эерэг, сөрөг үр дагавар

Орчин үеийн төрийн удирдлагын хүрээнд хөндөгдөж буй нэг гол асуудал нь үр дүнд суурилсан удирдлагын асуудал юм. Үр дүнд суурилсан удирдлагыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Үр дүнд суурилсан удирдлага нь 1) удирдлагын арга барил 2) хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал, боловсон хүчний удирдлагын төлөвлөгөөг хооронд нь системчлэн уялдуулан, бүх шатанд стратегийн гүйцэтгэлийн удирдлагыг бий болгож, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмждэг удирдлагын болон төлөвлөлтийн цогц тогтолцоо юм. (An Introduction to Results Management, Principles, Implication, and Application. ADB 2006)

Үр дүнд суурилсан удирдлага нь тодорхой үр дүнд хүрэхэд шууд болон шууд бусаар хувь нэмэр оруулж буй бүх оролцогчид өөрсдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг зорилгод үр дүнг (гарц, үр дагавар болон үр нөлөө) бий болгоход чиглүүлж, баталгаажуулдаг удирдлагын арга барил юм. Оролцогчид нь эргээд үр дүнгийн мэдээлэл, нотолгоог өөрсдийг үйл ажиллагаандаа бодлогын шийдвэр гаргахад зориулж ашигладаг.” (United Nations Development Group, Results-Based Management Handbook, 2011)

Үр дүнд суурилсан төсөвлөлт нь үр дүнд суурилсан удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ нь санхүүгийн болон санхүүгийн бус нөөцийн хуваарилалт болон түүнээс хүлээгдэж буй үр дүнгийн хоорондын хамаарал дээр үндэслэн нөөцийн зарцуулалтын хэмнэлттэй, үр ашигтай, үр дүнтэй байдалд анхаарлаа хандуулж, бүх нөөцийг босоо болон хэвтээ чиглэлд хамтрагч талуудын оролцоог бүрэн хангасан байдлаар нэгтгэн төсөвлөх үйл явц юм. Өөрөөр хэлбэл үр дүнд суурилсан төсөвлөлт гэдэг нь хуваарилсан санхүүжилтийг хэмжиж болохуйц үр дүнтэй нь холбон тооцоолсон төсвийг хэлдэг. (ЭЗХАХБ)

Улс орнуудад төрийн санхүүгийн /төсвийн/ шинэчлэл нь тодорхой үе шатуудыг дамжин хөгжиж байна. Энэхүү шинэчлэлийг багцлан авч үзвэл уламжлал ба үр дүнд чиглэсэн төсөвлөлт хэмээн 2 ангилж байна. Үүнд:

- Уламжлалт төсөвлөлт
  - Зүйл заалтын төсөв (Line-item budget) буюу орцод суурилсан төсөвлөлтийн арга
- Үр дүнд чиглэсэн төсөвлөлт
  - Гүйцэтгэлд суурилсан төсөв (Performance based budget) буюу гарцад суурилсан төсөвлөлтийн арга
  - Үр дүнд суурилсан төсөв (Result based budget) буюу үр дүнд суурилсан төсөвлөлтийн арга
  - Хөтөлбөрт суурилсан төсөв (Program based budget) буюу үр дүн, гарцад суурилсан төсөвлөлтийн арга
  - Тэг суурьт төсөв (Zero based budget) буюу үр дүн, гарцад суурилсан төсөвлөлтийн арга

Төсвийн төлөвлөлтийг боловсруулах эдгээр аргууд нь бие биенээсээ ялгагдах онцлог ялгаатай бөгөөд давуу, сул талуудтай. Аль нэг нь сайн гэсэн ойлголт байхгүй бөгөөд улс орон бүр өөрийн нөхцөл байдал, хөгжлийн үе шат, хэрэгцээ шаардлагадаа нийцүүлэн ашигладаг.




Эдгээр аргуудын давуу, сул тал онцлогыг танин мэдэхийн тулд эхлээд төрийн бодлогын үйл явцын логик холбоог ойлгох нь чухал юм.

Төрийн бодлого нь тодорхой орцыг татан төвлөрүүлж, хуваарилсны үндсэн дээр төрийн холбогдох байгууллага, албан хаагчид тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж, холбогдох талуудад гарцыг нийлүүлснээр үр дагавар, үр нөлөөг гаргахыг зорьж буй үйл ажиллагаа юм.

Энэхүү төрийн бодлогын үйл явцыг зураглалаар үзүүлбэл дараах зураглалыг гаргаж болох юм. Үүнд:

**Зураг 1. Төрийн бодлогын үйл явц**



Дээрх зураглалд дурьдагдсан ойлголтуудыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Орц – Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн, хүний, материалын (мөнгөн бус) болон институцийн (технологийн болон мэдээллийн гэх мэт) нөөц
- Үйл ажиллагаа - Орцыг ашиглан бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас хийж буй арга хэмжээ, ажил
- Гарц – Бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтнаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны эцэст холбогдох талуудад нийлүүлж байгаа бараа (бүтээгдэхүүн), үйлчилгээ
- Үр дагавар – Гарцаас шууд хамаарч бий болох өөрчлөлт
- Үр нөлөө – Гарцаас дам, үр дагавараас шууд хамааралтайгаар бий болох өөрчлөлт


Үүнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн жишээн дээр авч үзвэл:

- Орц – Жил бүрийн батлагдсан урсгал болон хөрөнгө оруулалтын төсөв (цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал+ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл+байр ашиглалттай холбоотой тогтмол зардал ... гэх мэт), тухайн жилд ажиллаж буй нийт албан хаагчид, барилга байшин, машин техник, тоног төхөөрөмж гэх мэт нөөц нь орц болно.
- Үйл ажиллагаа – Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан албан хаагчдын өдөр тутмын хийж буй ажил, арга хэмжээ
- Гарц – Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шүүн таслах ажиллагааны хүрээнд шийдвэрлэсэн нийт хэрэг (үйлчилгээ)
- Үр дагавар – Шүүхийн үйлчилгээний шууд нөлөөгөөр иргэд, аж ахуйн нэгжийн мэдлэг, ойлголт, үнэлэмж, институцийн болон зан үйлийн чадавхад гарсан гарч буй өөрчлөлт (иргэд, аж ахуйн нэгжийн эрх зүйн боловсролын түвшин, шүүхийн үйлчилгээний талаарх үнэлэмж, шүүхэд итгэх итгэл гэх мэт)
- Үр нөлөө – Бий болсон болон өөрчлөгдсөн үр дагавараас хамаарч ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль

дээдлэх зарчмыг дээдэлдэг шударга, зарчимч, хариуцлагатай иргэн төлөвших, эс төлөвших эсэх нь тодорхойлогдоно.

Төрийн бодлогын үйл явцыг төсөвлөлтийн аргуудтай уялдуулан зураглалаар илэрхийлвэл дараах зураглалыг гаргах боломжтой. Үүнд:

Зураг 2. Төрийн бодлогын үйл явц ба төсөвлөлт



Улс орнууд уламжлалт төсөвлөлтөөс үр дүнд чиглэсэн төсөвлөлт рүү аажмаар шилжиж байна. Уламжлалт ба үр дүнд чиглэсэн төсвийн ялгааг дараах зургаар илэрхийлэв. Үүнд:

Зураг 3. Уламжлалт төсөв ба Үр дүнд чиглэсэн төсвийн ялгаа



Эх сурвалж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын “ТҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТ: Үндсэн ойлголт, онцлог, хэрэгжүүлэлт” танилцуулгаас

Уламжлалт арга буюу **зүйл заалтын төсөв** нь орцод суурилсан төсөвлөлт ба орцыг санхүүжүүлдэг. Энэхүү аргаар төсөв боловсруулахдаа урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг (цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал+ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл+байр ашиглалттай холбоотой тогтмол зардал ... гэх мэт) Эдийн засгийн ангиллаар бүлэглэж хуваарилдаг.

Энэ аргын давуу тал нь төсвийн сахилга бат, хяналтыг сайжруулах боловч **ҮР ДҮН**-г орхигдуулдаг сул талтай.

Үр дүнд чиглэсэн төсөвлөлт нь хэд хэдэн төрлүүдтэй гэж үзэж болохоор байна.

**Гүйцэтгэлд суурилсан төсөв** нь гарцад суурилсан төсөвлөлт ба гарцыг санхүүжүүлдэг.

Төсвийн тухай хуулийн 4.1.56-д “гүйцэтгэлд суурилсан санхүүжилт” гэж хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, төрийн үйлчилгээний чанар зэрэг гарцын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг нийт дүнгээр нь төлөвлөж, хуваарилахыг хэлнэ хэмээн тодорхойлсон байна.

**Үр дүнд суурилсан төсөв** нь үр дүнд суурилсан төсөвлөлт ба үр дүнг санхүүжүүлдэг.

Үр дүнд суурилсан төсөвлөлт нь орц буюу ажлыг гүйцэтгэхэд шаардагдах нөөц дээр төвлөрч төсөвлөх бус илүү зорилгод үр дүн болон нийгэмд үзүүлэх эцсийн үр нөлөөнд төвлөрч төсвийн төлөвлөлтийг боловсруулдаг арга зүй ба гарцын буюу гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтөөс ялгаатай юм.

**Хөтөлбөрт суурилсан төсөв** нь мөн адил үр дүн болон гарцыг санхүүлдэг боловч үр дүн болон гарцыг төрийн бодлогын тодорхой чиглэл хүрээгээр багцалж авч үздэгээрээ онцлогтой.

Төсвийн тухай хуулийн 4.1.16-д "хөтөлбөр" гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг хилнэ хэмээн тодорхойлсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд жил бүрийн төсвөө “Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах хөтөлбөр”-өөр багцлан батлуулж авдаг.

**Тэг суурьт төсөв** нь мөн адил үр дүн болон гарцыг санхүүлдэг боловч төсвийн түүхээс илүү хөтөлбөрийн үр ашиг, хэрэгцээнд тулгуурлан санхүүжилтийг хуваарилдаг төсөв боловсруулах үйл явц юм. Уламжлалт болон хөтөлбөрт төсвөөс ялгаатай нь дараагийн төсөвт ямар ч зүйл автоматаар ордоггүй. Өөрөөр хэлбэл бодлогын орц, үйл ажиллагаа, гарц, үр дүнг шинээр тодорхойлдог.

Энэ аргын давуу тал нь өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг богино хугацаанд танин мэдэж түүнд нийцүүлэн төсвийг хуваарилах давуу талтай боловч ихээхэн хүч хүч, хөрөнгө санхүү, цаг хугацаа зарцуулдаг сул талтай.

Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөв нь төсвийн үр ашиг, үр өгөөжийг дээшлүүлэх давуу талтай боловч нөгөө талаар хариуцлагатай байдлыг дээшлүүлэхийг шаарддаг. Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг бүрэн нэвтрүүлэхийн тулд хөтөлбөрийн менежерт төсвийг бие даан захиран зарцуулах (орц, үйл ажиллагааг бие даан тодорхойлох, санхүүжүүлэх гэх мэт) тодорхой эрх мэдэл олгодог онцлогтой.

## 1.2. Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийн шинэчлэлийн тойм

Монгол Улс хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулан цэгцэлж, нэгдсэн зорилгод чиглүүлэн, бодлого төлөвлөлтийг төсөвлөлттэй уялдуулан хөгжлийн бодлогын нэгдмэл байдлыг хангах үүднээс Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2015 онд боловсруулан батлуулж, улмаар 2020 онд шинэчлэн найруулж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай нэртэйгээр батлан хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд Хөгжлийн бодлого, төлөвлөлт нь

- нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх

- төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх
- төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим

зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмуудыг тодорхойлж өгсөн байдаг.

Энэ нь Монгол улс Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд үр дүнд суурилсан удирдлагыг нэвтрүүлэхийг зорьж буй харуулж байна.

Монгол улсын төсвийн төлөвлөлтийн хөгжлийн үе шатыг авч үзвэл дараах үе шатыг дамжин хөгжиж байна хэмээн тодорхойлж болох юм. Үүнд:

1. Орцод суурилсан төсөвлөлт
2. Гарц буюу бүтээгдэхүүнд суурилсан төсөвлөлт
3. Хөтөлбөрт суурилсан төсөвлөлт
4. Үр дүнд суурилсан төсөвлөлт

Монгол Улс 2002 онд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийг баталж, хэрэгжүүлснээр орцод суурилсан төсөвлөлтөөс гарцад суурилсан төсөвлөлтөд шилжих алхам хийсэн боловч тодорхой нөхцөл байдлын улмаас бүрэн нэвтрүүлж чадаагүй.

Улмаар 2011 онд Төсвийн тухай хуулийг баталж, хэрэгжүүлснээр хөтөлбөрт суурилсан төсөвлөлт рүү шилжсэн.

Төсвийн тухай хуулийн 22.2-т төсвийг

- төсвийн шатлалаар;
- төсвийн захирагчаар;
- эдийн засгийн ангиллаар;
- хөтөлбөрөөр;
- арга хэмжээгээр;
- санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилна хэмээн заасан.

Мөн хуулийн 31.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна”

- санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх;
- хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;
- эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх; гэсэн шаардлагуудыг тодорхойлж өгсөн байдаг.

Гэвч жил бүрийн төсвийг батлахдаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн үзүүлэлтүүдийг тодорхойлж байгаа боловч хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн гарц, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрт шаардагдах төсвийг нарийвчлан хуваарилж чадахгүй уламжлалт арга буюу зүйл заалтын төсвөөр, Эдийн засгийн ангиллаар хөтөлбөрийн төсвийг багцаар нь баталж байна.

Энэ нь Монгол улс хөтөлбөрт суурилсан төсөвлөлтөд бүрэн шилжиж чадаагүй байгааг харуулж байгаа юм.

Иймд Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг үр дүнд суурилсан байдлаар боловсруулах хүрээнд 2021 оноос Европын холбооны санхүүжилтээр НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр ЭЗХЯ, Сангийн яам, Монгол улсын Засгийн газраас дараах эрх зүйн болон арга, аргачлалын шинэчлэлийг хийж байна.

- Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоол. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам (Хавсралт 1)
- Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/25 дугаар тушаалын хавсралт. Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал (Хавсралт 2)
- Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалын хавсралт. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал (Хавсралт 3)
- Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалын хавсралт. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал (Хавсралт 4)
- Сангийн яам. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон холбогдох маягтууд
  - 6.1\_ҮДСТ төсвийн саналын маягт\_УТ (Хавсралт 5)
  - 6.2\_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар\_УТ (Хавсралт 6)
  - 6.3\_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар\_ОН (Хавсралт 7)
  - 6.4\_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар\_ОН (Хавсралт 8)
  - 6.5\_ҮДСТ Төсвийн шалгах хуудас (Хавсралт 9)

### 1.3. Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлсэн төрийн байгууллагууд, тэдгээр гарсан ахиц, шийдвэрлэвэл зохих тулгамдаж буй асуудал

Монгол улс 2011 онд Төсвийн тухай хуулийг баталж, хэрэгжүүлснээр хөтөлбөрт суурилсан төсөвлөлт рүү шилжсэн боловч хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн гарц, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрт шаардагдах төсвийг нарийвчлан хуваарилж чадахгүй уламжлалт арга буюу зүйл заалтын төсвөөр, Эдийн засгийн ангиллаар хөтөлбөрийн төсвийг багцаар нь баталж байна. Энэ нь Монгол улс хөтөлбөрт суурилсан төсөвлөлтөд бүрэн шилжиж чадаагүй байгааг харуулж байгаа юм.

Хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэх хүрээнд дараах сорилттой тулгарч байна. Үүнд:

- Хөтөлбөрийн гарц, үр дүнг ялган тодорхойлж бүрэн чадахгүй байна.
- Төсвийг хөтөлбөрөөр багцлан тодорхойлж байгаа боловч уламжлалт арга буюу зүйл заалтын төсвөөр, Эдийн засгийн ангиллаар хөтөлбөрийн төсвийг багцаар нь баталж байна.
- Хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн гарц, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрээр төсвийг нарийвчлан хуваарилахын тулд төрийн байгууллагуудыг үндсэн үйл ажиллагааны эцэст нийлүүлж буй гарц, хэрэгжүүлж буй арга хэмжээ тус бүрээр зардлын төвүүдийг тодорхойлох шаардлага үүсч байна.
- Хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийг бүрэн нэвтрүүлэхийн тулд хөтөлбөрийн менежерт төсвийг бие даан захиран зарцуулах (орц, үйл ажиллагааг бие даан тодорхойлох, санхүүжүүлэх гэх мэт) тодорхой эрх мэдэл олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага үүсч байна.
- Хөтөлбөрийн үр дүн, гарцад суурилсан санхүүжилтийг олгохын тулд хөтөлбөрийн үр дүн, гарцын шалгуур үзүүлэлт, мэдээллийн бэлэн байдлыг хангах шаардлагатай байна.

Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлэх хүрээнд Сангийн яамнаас 2021 онд Эрүүл мэнд, 2022 онд боловсролын салбарт гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг туршин нэвтрүүлж байна. Цаашид Мэргэжлийн боловсрол, Соёл, Спорт, Байгаль орчны салбарт нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Эх сурвалж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын “ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТ: Үндсэн ойлголт, онцлог, хэрэгжүүлэлт” танилцуулгаас

Эрүүл мэнд, боловсролын салбарт нэвтрүүлсэн гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн үр ашиг, үр өгөөжийг бүрэн тооцоогүй байгаа бөгөөд дараах эерэг, сөрөг үр дагаварууд гарч байгааг холбогдох талууд хөндөж байна. Үүнд:

- Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлсэн байгууллагуудын үр ашиг, үр өгөөж харилцан адилгүй байна.
- Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн үр ашиг, үр өгөөж нь удирдлагын арга барил, хариуцлага, идэвхи санаачлагаас ихээхэн хамаарч байна.
- Гүйцэтгэлийг баримт нотолгоонд үндэслэн санхүүжүүлэхийн тулд албан хаагчдын ажлын ачаалал ихсэх, бичиг цаас үйлдвэрлэх байдал нэмэгдэх байдал үүсч байна.
- Тодорхой үйл ажиллагаануудад мэдэгдэхүйц үр дүн гарч байна. Жишээлбэл, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, эмийн хөнгөлөлт гэх мэт

2023 оноос Европын холбооны санхүүжилтээр НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр Сангийн яамнаас ХНХ болон ХХААХҮ асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэх туршилтыг хийсэн.

Мөн Сангийн яамнаас 2024 онд дараах төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэх туршилтыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үүнд:

**Хүснэгт 1. 2024 оны төсвийн төлөвлөлтийн хүрээнд Үр дүнд суурилсан төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэх туршилтыг хэрэгжүүлж буй ТЕЗ-ийн хөтөлбөрүүд**

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Хөтөлбөрийн нэр
1	ХНХ-ын сайд	Нийгмийн халамж
		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
		Хүүхдийн хөгжил, хамгааллын
2	ХХААХҮ-ийн сайд	Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр
		Газар тариаланг хөгжүүлэх хөтөлбөр
		Бусад хөтөлбөрүүд
3	Соёлын сайд	Соёл урлаг хөтөлбөр
4	Биеийн тамир спортын улсын хороо	Биеийн тамир спортын хөтөлбөр
5	БШУ-ны сайд	Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөр
6	Дорноговь аймгийн Засаг дарга	Зарим хөтөлбөрүүд

Дээрх туршилтын үр ашиг, үр өгөөжийн үр ашиг, үр өгөөжийг бүрэн тооцоогүй байна.

#### 1.4. Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлэхэд анхаарах асуудал

Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлэх хүрээнд дараах давуу, сул тал болон боломж, эрдсэл учирч болохоор байна. Үүнд:

**Хүснэгт 2. Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлэх давуу, сул тал болон боломж, эрдсэл**

Давуу тал	Сул тал	Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>Салбарын гүйцэтгэх чиг үүрэг тодорхой</li> <li>ТЕЗ-ийн болон харьяа байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд тодорхой</li> <li>Шалгуур үзүүлэлтийн мэдээллийн бэлэн байдал харьцангуй сайн хангагдсан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Анхан болон давж заалдах шатны хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг тус бүр ангилж авч үзэх боломжтой байгаа боловч төрөл тус бүр дэх хэрэг маргааны онцлог шинж, маргаан шийдвэрлэх процессийн ялгаатай байдлаар нарийвчлан авч үзэх мэдээллийн бэлэн байдал бүрэн хангагдаагүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Харьяа байгууллагуудтай байгуулах үр дүнгийн гэрээ, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Шүүхийн тамгын газар, шүүх, шүүгч тус бүрээр гаргах</li> <li>Харьяа байгууллагуудын гүйцэтгэлийг дүгнэх, гүйцэтгэлийг сайжруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг тодорхойлохдоо тооцоолол дээр алдаа гаргавал жилийн эцэст зорилтот түвшиндээ хүрч чадахгүй байх</li> </ul>

Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлснээр дараах эерэг үр дагавар гарах боломжтой. Үүнд:

- Хөтөлбөрийн үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх
- Төсвийн зардал хэмнэх, зардалд дүн шинжилгээ хийх
- Харьяа байгууллагуудтай байгуулах үр дүнгийн гэрээ, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг Шүүхийн тамгын газар, шүүх, шүүгч тус бүрээр гаргах
- Харьяа байгууллагуудын гүйцэтгэлийг дүгнэх, гүйцэтгэлийг сайжруулах
- Нотолгоонд суурилсан төсвийн санал боловсруулж ТЕЗ-ийн төсвийн төслийг холбогдох байгууллагаар батлуулах, төсвийг нэмэгдүүлэх

Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлснээр ямар нэг сөрөг үр дагавар үүсэхгүй хэмээн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хувьд дүгнэж байна. Учир нь гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг нэвтрүүлсэн байгууллагуудад гүйцэтгэлийг баримт нотолгоонд үндэслэн санхүүжүүлэхийн тулд албан хаагчдын ажлын ачаалал ихсэх, бичиг цаас үйлдвэрлэх байдал нэмэгдэх байдал үүсч байна гэсэн шүүмжлэл гарч байгаа боловч ТЕЗ-ийн үйл ажиллагаа нь тодорхой, үйл ажиллагаа нь баримтаар нотлогдох учир нэмэлт цаас үйлдвэрлэх шаардлага байхгүй.

Үр дүнд, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг Шүүхийн салбарт нэвтрүүлэхэд дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлага үүсч байна. Үүнд:

- Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэх эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шүүн таслах ажиллагааны гарцыг “Хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хэргийн хувь” гэсэн шүүн таслах ажиллагааны чанарын шалгуур үзүүлэлтээр тооцохоор төлөвлөсөн ба энэхүү үзүүлэлтийн мэдээллийн найдвартай байдлыг нягтлах
- Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх хуулийн хугацааг эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргээр ерөнхий байдлаар хуульчилсныг дотор нь ээдрээ төвөгтэй хэрэг, энгийн хэрэг, хялбар хэрэг гэх мэт онцлогтой байдлаар хуульчлан зохицуулах шинэчлэлийг хэрэгжүүлэх

## Хоёр. ШЕЗ-ийн тез-ийн хөтөлбөрийн үр дүн, үр дүнгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох нь

### 2.1. ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр дүн, үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлох нь

ШЕЗ-ийн ТЕЗ-ийн 2024 оны үр дүнд суурилсан төсвийн төсөл боловсруулах ажил зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ Европын холбооны санхүүжилтээр НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Монгол улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн дэмжлэгтэйгээр Сангийн яамнаас боловсруулсан Үр дүнд суурилсан төсвийн саналын маягтыг ашиглахыг санал болгосон.

Уг саналын маягт дараах бүрдэл хэсэгтэй болно. Үүнд:

- Хүснэгт №1: Маягт А1 – Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг 2024-2026 оноор гаргах хүснэгт
- Хүснэгт №2: Маягт А2 – Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу хөтөлбөрийн гарц, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай урсгал болон хөрөнгийн зардлыг тооцох хүснэгт
- Хүснэгт №3: Маягт Б – Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын төсвийн тооцооллыг үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх арга хэмжээг төсөв хураалах Эдийн засгийн ангилалтай уялдуулан нэгжийн өртөгөөр, урсгал болон хөрөнгийн зардлаар тооцох хүснэгт
  - Ажлын хүснэгт-1: Арга хэмжээг цааш задлах тохиолдолд ашиглах Хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийгдэх арга хэмжээний зардлын төсвийн тооцооллын хүснэгт
  - Ажлын хүснэгт-2: Шинээр арга хэмжээ төлөвлөх, задлах тохиолдолд ашиглах Шинэ арга хэмжээний хүрээнд хийх ажлын өртгийн тооцооллын хүснэгт
- Хүснэгт №4: Хөтөлбөрийн үр дүнгийн гол шалгуур үзүүлэлт, үйл ажиллагааны төсөв, нэгжээр тооцох ажлын хүснэгт. Энэ ажлын хүснэгт нь ТЕЗ-ийн харьяалах төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн төсвийг тооцоход ашиглагдана.
- Хүснэгт №5: ТЕЗ-ийн үр дүнд суурилсан хөтөлбөрт төсвийн саналын нэгтгэл гаргах хүснэгт
- Хүснэгт №6: ТЕЗ-ийн үр дүнд суурилсан төсвийн санал /Эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар/ гаргах хүснэгт
- Хүснэгт №7: ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн нэгтгэлийг гаргах хүснэгт

Хүснэгт №1: Маягт А1 – Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг 2024-2026 оноор гаргах хүснэгтийг бөглөхдөө анхаарах асуудлыг дараах байдлаар тодорхойлж, зөвлөмжийг өгч ажилласан. Үүнд:

- Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлохдоо хөтөлбөрийн гарц буюу жишээбэл, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шууд нөлөөгөөр гарах эерэг өөрчлөлтийг тодорхойлох шаардлагатайг анхаарах
- Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо хэд хэдэн шалгуур үзүүлэлт тодорхойлох тохиолдолд нийлмэл хэмжигдэхүүн буюу индекс тооцох



- Индекс тооцохдоо арифметик дундаж болон жигнэсэн дундажын аргын аль нэгийг ашиглах
- Хөтөлбөрийн үр дүнгийн суурь түвшинг тодорхойлохдоо тухай үзүүлэлтийн хамгийн сүүлийн баталгаажсан он, түвшинг авч ашиглах
- Хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшинг тодорхойлохдоо Сангийн ямаар хянагдах төсвийн өсөлт, бууралттай уялдуулан тодорхойлох /зөвшилцөх/. Өөрөөр хэлбэл холбогдох байнгын хороогоор хянагдсан төсвийн хүрээнд гарах хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшин болон үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсвийн хүрээнд гарах хөтөлбөрийн үр дүнгийн зорилтот түвшинг тодорхойлж, төсөв танагдсан тохиолдолд үр дүнгийн зорилтот түвшинг төсөвтэй харгалзуулан бууруулах

Ингээд хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг 2024-2026 оноор гаргах ажилд холбогдох ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, тухай бүр санал, зөвлөмж өгч ажилласан.

## 2.2. Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг тодорхойлох нь

Хүснэгт №2: Маягт А2 – Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу хөтөлбөрийн гарц, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг тодорхойлох ажлын хүснэгтийг бөглөхдөө анхаарах асуудлыг дараах байдлаар тодорхойлж, зөвлөмжийг өгч ажилласан. Үүнд:

- Үйл ажиллагаа буюу гарцыг тодорхойлохдоо Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг ШЕЗ, Ерөнхий зөвлөлийн ажлын алба, Шүүхийн Тамгын газар гэсэн ангиллаар ялгаж тодорхойлох
- Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо тоо болон чанарын шалгуур үзүүлэлт тодорхойлох
- Шалгуур үзүүлэлтийн мэдээллийн найдвартай болон бэлэн байдлыг хангах
- Мэдээллийн бэлэн байдал хангагдаагүй зайлшгүй тооцох шаардлагатай шалгуур үзүүлэлтийг 2023 онд багтаан тооцох аргачлалыг нарийвчлан боловсруулж, тооцох ба холбогдох баганыг бөглөхдөө суурь түвшин дээр шинээр тооцох, зорилтот түвшин дээр суурь түвшин нэмэх нь “а” хувь гэсэн аргачлалаар бөглөх
- Зорилтот түвшинг тодорхойлохдоо өнгөрсөн 6 жилийн гүйцэтгэл болон цаашдын 3 жилийн таамаглалыг харгалзах үзэх
- Үйл ажиллагаа буюу гарцын суурь түвшинг тодорхойлохдоо тухай үзүүлэлтийн хамгийн сүүлийн баталгаажсан он, түвшинг авч ашиглах
- Үйл ажиллагаа буюу гарцын зорилтот түвшинг тодорхойлохдоо Сангийн ямаар хянагдах төсвийн өсөлт, бууралттай уялдуулан тодорхойлох /зөвшилцөх/. Өөрөөр хэлбэл холбогдох байнгын хороогоор хянагдсан төсвийн хүрээнд гарах хөтөлбөрийн үр дүнг хангах үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин болон үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсвийн хүрээнд гарах хөтөлбөрийн үр дүнг хангах үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг тодорхойлж, төсөв танагдсан тохиолдолд зорилтот түвшинг төсөвтэй харгалзуулан бууруулах
- Үйл ажиллагааг тодорхойлохдоо анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр ангилж тодорхойлох
- Үйл ажиллагааг тодорхойлохдоо эрүү, иргэн, захиргаа болон эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаагаар ангилж тодорхойлох

Ингээд хөтөлбөрөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу хөтөлбөрийн гарц, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшинг тодорхойлох ажилд холбогдох ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, тухай бүр санал, зөвлөмж өгч ажилласан.

### 2.3. Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх арга хэмжээг тодорхойлох нь

Хүснэгт №3: Маягт Б – Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх арга хэмжээг тодорхойлох ажлын хүснэгтийг бөглөхдөө анхаарах асуудлыг дараах байдлаар тодорхойлж, зөвлөмжийг өгч ажилласан. Үүнд:

- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх арга хэмжээг тодорхойлохдоо төсөв хуваарилах зүйл заалтын арга буюу Эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалтай уялдуулан тодорхойлох
- Нэмэлт арга хэмжээг тодорхойлохдоо Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнээс тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг ялгаж холбогдох үйл ажиллагаатай уялдуулан тусгах
- Арга хэмжээг цааш задлах болон шинээр арга хэмжээ төлөвлөх, задлах тохиолдолд Ажлын хүснэгт-1, Ажлын хүснэгт-2-ыг ашиглан төсөв хуваарилах зүйл заалтын арга буюу Эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалтай уялдуулан тодорхойлох

Ингээд хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд гүйцэтгэх арга хэмжээг тодорхойлох ажилд холбогдох ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, тухай бүр санал, зөвлөмж өгч ажилласан.

Хүснэгт №3: Маягт Б –д тусгагдах арга хэмжээ тус бүрийн томъёоллыг эцэслэн тодорхойлсон.

### 2.4. Хөтөлбөрийн үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтийг Төсвийн шууд захирагч тус бүрээр тодорхойлох нь

Хүснэгт №4: – Хөтөлбөрийн үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтийг Төсвийн шууд захирагч тус бүрээр тодорхойлох ажлын хүснэгтийг бөглөхдөө анхаарах асуудлыг дараах байдлаар тодорхойлж, зөвлөмжийг өгч ажилласан. Үүнд:

- Тус хүснэгтийг бөглөхдөө Маягт А2-т боловсруулсан Шүүхийн Тамгын газрын үндсэн чиг үүргийн хүрээнд тодорхойлсон үйл ажиллагаа буюу гарцыг үндэслэх
- Гол шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг сонгох. Боломжгүй тохиолдолд хөтөлбөрийн үр дүнг хангах үйл ажиллагааны гол шалгуур үзүүлэлтийг сонгох
- Гол шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо чанарыг шалгуур үзүүлэлтийг сонгох
- Суурь түвшинг тодорхойлохдоо тухай үзүүлэлтийн хамгийн сүүлийн баталгаажсан он, түвшинг авч ашиглах
- Зорилтот түвшинг тодорхойлохдоо Сангийн ямаар хянагдах төсвийн өсөлт, бууралттай уялдуулан тодорхойлох /зөвшилцөх/. Өөрөөр хэлбэл холбогдох байнгын хороогоор хянагдсан төсвийн хүрээнд гарах хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин болон үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсвийн хүрээнд гарах хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг тодорхойлж, төсөв танагдсан тохиолдолд зорилтот түвшинг төсөвтэй харгалзуулан бууруулах

Ингээд хөтөлбөрийн үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтийг Төсвийн шууд захирагч тус бүрээр тодорхойлох ажилд холбогдох ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, тухай бүр санал, зөвлөмж өгч ажилласан.



## ГУРАВ. ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааны зардлын төсвийн тооцоолол

### 3.1. ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг Төсвийн эдийн засгийн ангилалтай уялдуулах нь

ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээний зардлын төсвийн тооцоололыг хийх ажлыг зөвлөн чиглүүлэх хүрээнд зардлыг арга хэмжээ тус бүрээр Эдийн засгийн ангилалтай уялдуулан хуваарилахад хүндрэл учирсан.

Иймд зардлыг хуваарилахдаа дараах алхамтайгаар хянагдсан төсвийг ангилахыг санал болгож ажилласан. Үүнд:

- **Алхам 1.** Хянагдсан төсвийг /эдийн засгийн ангилал/ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эвлэрүүлэн зуучлал, шүүхийн захиргаа гэсэн 3 хэсэгт задлах
- **Алхам 2.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг анхан болон давж заалдах шатаар, Шүүхийн захиргааны зардлыг ШЕЗ, Ажлын алба, Шүүхийн тамгын газраар задлах
- **Алхам 3.** Анхан болон давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн гэсэн төрлөөр ангилах
- **Алхам 4.** Зохист ачааллыг тооцож үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн аргачлалын хүрээнд хянагдсан төсвийг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага, шаардлагатай төсвийг тооцоолсон
  - Зохист ачааллаас давсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай шүүгчийн тоо, төсөв болон зохист ачааллаас давсан шүүгчдэд олгох урамшууллын дүнг гаргах
  - Бичиг хэргийн зардлыг хэрэг, маргааны тоотой уялдуулан нэгжийн өртөгөөр тооцох
  - Нормативт зардалд шүүх хуралдааны явцад эрүүл мэндийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх эм, эмийн хэрэгслийн багцын бэлэн байдлыг хангах зардлыг тооцох
  - Шүүхийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан 2024 онд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний зардлыг тооцох
- **Алхам 5.** Үр дүн, гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн хүрээнд тооцсон төсөвтэй үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг тодорхойлох

Хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг Төсвийн эдийн засгийн ангилалтай уялдуулан төлөвлөх ажлын хүснэгтийг бөглөхдөө анхаарах асуудлыг дараах байдлаар тодорхойлж, зөвлөмжийг өгч ажилласан. Үүнд:

- Зүйл заалтын төсөв буюу Эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалын төсвийг арга хэмжээ тус бүртэй уялдуулан хуваарилах
- Доороос дээш буюу Шүүхийн тамгын газрын төсвийг дээр дурьдсан алхамтайгаар задалж, задалсан төсвийг хооронд нь нь нэгтгэх замаар /Тамгын газрын төсвүүдийг нэгтгэх замаар/ үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг гаргах
- Хүснэгт №4: – Хөтөлбөрийн үр дүнгийн гол шалгуур үзүүлэлтийг Төсвийн шууд захирагч тус бүрээр гаргасан ажлын хүснэгтийн үйл ажиллагааны зардлын дүн нь Маягт А2-т тусгагдсан тухайн үйл ажиллагааны зардлын дүн болох. Өөрөөр хэлбэл эдгээр дүнгүүд тулах ёстой
- Маягт А2-т тусгагдсан тухайн үйл ажиллагааны зардлын дүнг Маягт Б-д тусгагдсан тухайн үйл ажиллагааны зардлын дүн болох. Өөрөөр хэлбэл эдгээр дүнгүүд тулах ёстой

- Маягт Б-д тусгагдсан арга хэмжээний зардлыг Эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалтай уялдуулахын тулд цааш задлах шаардлагатай тохиолдолд Ажлын хүснэгт-1, Ажлын хүснэгт-2-ыг ашиглан арга хэмжээг дэд ажлуудад задалж зардлыг тооцох

Ингээд хөтөлбөрийн үйл ажиллагаа, арга хэмжээний зардлыг Төсвийн эдийн засгийн ангилалтай уялдуулан төлөвлөх ажилд холбогдох ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, тухай бүр санал, зөвлөмж өгч ажилласан.

### 3.2. ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгжийн өртөг ба нийт төсвийг тооцох нь

ШЕЗ-ийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгжийн өртөг тооцох хүрээнд Өртөг тооцох ажлын хэсэгтэй ярилцсаны үндсэн дээр төсөв хуваарилах эдийн засгийн ангилалын “Хангамж, бараа материалын зардал”-аас бичиг хэрэг, тээвэр, шатахуун, Шуудан, холбоо, интернэтийн зардал, Ном, хэвлэл зардлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын өртөгт оруулан тооцож нэгж хэргийг шийдвэрлэхэд шаардлагатай зардлыг гаргуулсан.

Учир нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэж буй хэрэг, маргааны онцлог шинж, хийгдэх процессийн ялгаатай байдлыг харгалзаж үзэхгүйгээр нэгжийн өртөг тооцох нь тооцооллын алдаа гарах магадлалтай гэж үзсэн.

Цаашид үндсэн үйл ажиллагааны хүрээнд шийдвэрлэж буй хэрэг, маргааны онцлог шинж, хийгдэх процессийн ялгаатай байдлыг харгалзаж үйл ажиллагаа, арга хэмжээг нарийвчлан задлах шаардлагатай байгаа нь ажиглагдсан. Үүний дараагаар нэгжийн өртөгийг бодитоор тооцох боломж бүрдэнэ.



## Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын Шүүхийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сангийн яам. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон холбогдох маягтууд
- Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалын хавсралт. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал
- Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалын хавсралт. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал



## ХАВСРАЛТЫН жагсаалт

- Хавсралт 1: Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоол. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам
- Хавсралт 2: Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/25 дугаар тушаалын хавсралт. Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах аргачлал
- Хавсралт 3: Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалын хавсралт. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал
- Хавсралт 4: Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/26 дугаар тушаалын хавсралт. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал
- Хавсралт 5-9: Сангийн яам. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж болон холбогдох маягтууд
  - 6.1\_ҮДСТ төсвийн саналын маягт\_УТ (Хавсралт 5)
  - 6.2\_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар\_УТ (Хавсралт 6)
  - 6.3\_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар\_ОН (Хавсралт 7)
  - 6.4\_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар\_ОН (Хавсралт 8)
  - 6.5\_ҮДСТ Төсвийн шалгах хуудас (Хавсралт 9)

